



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/153


Улаанбаатар хот

Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөлийн ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хагас жил тутам танилцуулж байхыг Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Баярт/-д үүрэг болгосугай.


САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080498

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 17-ны өдрийн
А/ дугаар тушаалын хавсралт



ХИМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХОРДЛОГЫН МЕНЕЖМЕНТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Эрүүл мэндийн яамны дэргэдэх Химийн аюулгүй байдал, хордлогын менежментийг зохицуулах зөвлөл/ цаашид ХАБХМЗЗ гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 ХАБХМЗЗ нь Монгол улсын хэмжээнд хэрэглэгдэж буй химийн бодисын хэрэглээ, хордлогоос урьдчилан сэргийлэх, хордлогын үед авах хариу арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

1.3 ХАБХМЗЗ нь Монгол улсын хэмжээнд ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх зорилгоор хэрэглэгдэх бодисыг бүртгэх, бодисын хор нөлөө болон хэрэглэгдэж байгаа бодисуудын тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх, стандартын шаардлага хангасан бодисыг хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн бодлогоор хангах эрх бүхий орон тооны бус, мэргэжлийн зөвлөл байна.

1.4 ХАБХМЗЗ нь Эрүүл мэндийн тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичиг, бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

1.5 ХАБХМЗЗ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.6 ХАБХМЗЗ-ийн дарга, гишүүд нь ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргана.

Хоёр. Зөвлөлийн бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1 ХАБХМЗЗ нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд дарга гишүүдийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилж ажиллуулна.

2.2 ХАБХМЗЗ-ийн ажлын албаны үүргийг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар гүйцэтгэнэ.

2.3 ХАБХМЗЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байх ба хуралдааныг зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

2.4 ХАБХМЗЗ-ийн хуралдаан гишүүдийн ердийн олонхийн оролцсоноор хүчин төгөлдөрт тооцогдож, асуудлыг хуралдаанд оролцогсдын олонхийн саналаар

шийдвэрлэж, дүгнэлт зөвлөмж гаргана. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.5 Зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд ирэхгүй тохиолдолд шалтгаанаа Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргад хурал хуралдахаас 1 хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр ирүүлнэ.

2.6 Зөвлөлийн гишүүний эзгүйд түүнийг орлуулахгүй.

2.7 Тухайн хэлэлцэж буй асуудалтай холбоотой ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөлд хамаарал бүхий гишүүнийг уг асуудлыг хэлэлцэхэд оролцуулахгүй.

2.8 Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг шаардлагатай гэж үзвэл дахин хэлэлцэхээр хойшлуулах.

2.9 ХАБХМЗЗ нь Эрүүл мэндийн тухай хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.9.1 Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодистой холбогдох материалыг шаардлагатай тохиолдолд бүртгүүлэгчээс шаардах;

2.9.2 Хуулинд заасан хамаарах асуудлын хүрээнд олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, олон улс, орон нутгийн чанартай хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах;

2.9.3 Холбогдох байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисын чанар аюулгүй байдлын асуудлаар эксперт хийхэд мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах;

2.9.4 Бүртгүүлэх бодисын бүртгэлд шаардагдах үйл ажиллагааны зардлын хэмжээг батлах;

2.9.5 Бүртгэлийн материалд дүгнэлт гаргах орон тооны бус шинжээчийн ажиллах журмыг батлах;

Гурав. Зөвлөлийн даргын чиг үүрэг

3.1 Зөвлөлийн хуралдааныг ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх зорилгоор хэрэглэгдэх бодисын бүртгэлтэй холбоотой асуудлаар 6 сард 1 удаа зарлан хуралдуулж, хуралдааныг удирдах;

3.2 Зөвлөлийг шаардлагатай тохиолдолд ээлжит бусаар зарлан хуралдуулах;

3.3 Зөвлөлийн хурлын төлөвлөгөө батлах;

3.4 Хуралдаанаас гарсан шийдвэрийг тэмдэглэлээр баталгаажуулж, шаардлагатай гэж үзсэн зарим асуудлыг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх чиглэл өгөх;

3.5 Гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих ба явцын талаар гишүүдэд мэдэгдэх.

Дөрөв. Нарийн бичгийн даргын чиг үүрэг

4.1 Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Нийгмийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөн боловсруулж, ХАБХМЗЗ-ийн даргаар батлуулан, хуралдааны бэлтгэлийг хангах;

4.2 ХАБХМЗЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой бичиг баримтыг хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд цахимаар тараах;

4.3 Хуралдааны тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлийн хувийг холбогдох хувь хүн, байгууллагад хүргүүлэх;

4.4 Зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

4.5 ХАБХМЗЗ-ийн архив, бичиг хэргийг хөтлөн явуулах.

4.6 Бодисын бүртгэлийн үйл ажиллагааны зардлын тайланг бүтэн жилээр зөвлөлийн хуралд танилцуулах.

---0---0---0---